



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/07

Хужирт сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2017 оны “Угийн бичгийн хөтлөлтийг эрчимжүүлэх тухай” А/01 дүгээр албан даалгаварыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголчуудын оршихуйн соёлын нэн үнэт өв “Угийн бичиг”-ээ үеэс үе дамжуулан үр хүүхэд, хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, сумын нийт ард, иргэдэд сурталчилах, өрх бүрээр хөтлүүлэх бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Сумын Номын сангийн эрхлэгч

Ерөнхий боловсролын сургуулийн Монгол хэл бичгийн багш нар

Насан туршийн боловсролын багш

Боловсролын байгууллагын дарга, эрхлэгч нар

Багийн Засаг дарга нар

2. Сум, багийн түвшинд “Угийн бичиг хөтлөх” ажлыг эрчимжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсэгт, төрийн албан хаагч бүр өөрийн удмын “Угийн бичгийг хөтөлж”, ойр дотно найз нөхдийн хүрээнд 5 өрхийг сонгон “Угийн бичиг”-ээ хөтөлж хэвшүүлж ажиллахыг төрийн болон аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч, Багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийн явцыг жилд 2 удаа Засаг даргын дэргэдэх зөвлөлд танилцуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (З.Цэцэгмаа), Соёлын төвийн эрхлэгч (О.Долгормаа) нарт даалгасугай.

ДАРГА

Д.БАТБАЯР



622401013

D:Alban bichig;Zahiramj 2024